

АНУ-ЫН ВИЗ МЭДҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД

1. Цагаачлалын бус визний цахим маягтын (DS-160) баталгаажуулсан хуудас DS-160 маягтын тухай нэмэлт мэдээллийг <https://www.ustraveldocs.com/mn/mn-niv-ds160info.asp> руу орж авна уу.
2. АНУ-д байх хугацаанаас хойш наад зах нь 6 сарын хугацаанд хүчинтэй паспорт болон хуучин пастортнууд
3. Иргэний цахим үнэмлэх
4. Нэг (1) хувь 2"х2" (5смх5см) зураг. Цээж зурганд тавигдах шаардлагыг <https://www.ustraveldocs.com/mn/mn-niv-photoinfo.asp#overview> -ээс үзнэ үү.
5. Визний хураамжны баримт: ягаан болон шар хувь хоёуланг нь; /МҮХАҮТ-аас баримтийг олгоно/
6. Ярилцлагын цаг товлосныг нотлох хуудас /МҮХАҮТ-аас олгоно/
7. Урилга /МҮХАҮТ-аас олгоно/
8. Бусад нэмэлт материалууд:
 - АНУ-ийн ЭСЯ-нд хандсан албан байгууллага нь батлан даах тухай албан бичиг (англи хэл дээр). Үүнд: бизнес аялалд оролцогчийн мэдээлэл, компанийн товч танилцуулга, аялалын зорилго, хугацаа, зардал хариуцагч зэргийг дурьдсан байх).
 - МҮХАҮТ-д хандсан бизнес айлчлалд оролцогчийг хамруулах тухай албан бичиг (англи хэл дээр). Үүнд: Компанийн маш товч мэдээлэл, зардлыг хариуцах тухай дурьдах
 - Нийгмийн даатгалын дэвтэр эх хувь
 - Нийгмийн даатгалын лавлагаа
 - Гэрлэлт бүртгэлийн лавлагаа (баталгаат орчуулгатай англи хэл дээр)
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээ (баталгаат орчуулгатай англи хэл дээр)
 - Ажлын газрын тодорхойлолт, цалингийн баталгаа болон сүүлийн 3 сарын цалингийн хуулга (баталгаат орчуулгатай англи хэл дээр)
 - Цагдаагийн тодорхойлолт (анх удаа виз мэдүүлэгчид КТМС-ийн зүүн талд байрлах Цагдаагийн Ерөнхий Газар, Лавлагааны сан-гаас урилгын хуулбарыг авч тодорхойлолтыг авна). (баталгаат орчуулгатай англи хэл дээр)
 - Эх орондоо буцаж ирэхийг тань батлах үл хөдлөх хөрөнгө, өмч хөрөнгө болон эд хөрөнгийн баталгаа
 - Ойрын төрөл садан тань АНУ-д аж төрдөг бол:
 - Төрөл садангийнхаа статусын баталгааны хуулбарыг (жишээ нь Ногоон карт, иргэншлийн гэрчилгээ, хүчинтэй виз гэх мэт)
 - Өмнө нь АНУ-д зорчиж байсан бол:
 - Ямар ажлаар явж байсан зэргийг тодорхойлсон ажил олгогчийн тань захиа
 - Таны хилээр орж гарсныг болон визний статусыг нотлох баримт бичгүүд

Анхааруулга: Хуурамч бичиг баримт бүрдүүлэхийг хатуу хориглоно. Залилан эсвэл хуурамч мэдээлэл мэдүүлсэн тохиолдолд виз олгохыг бүрмөсөн татгалзах болно. Бичиг баримтын эх хувь хэзээд давууд тооцогддог учраас ярилцлаганд эх хувиа авчрах ёстой. АНУ-ын Элчин Сайдын Яам/Консулын Хэлтэс рүү аливаа бичиг баримтаа факс, и-мэйл эсвэл шуудангаар илгээж болохгүй.

!!! АНУ руу зорчих 10 жилийн хугацаатай виза өмнө нь авч байсан, тухайн визаны хугацаа дууссан, хугацаа дуусахаас өмнө ямар нэгэн зөрчил гаргаж байгаагүй виза мэдүүлэгч нь онлайнгаар виза мэдүүлэх боломжтой.